In 2004, the UNESCO World Heritage Committee inscribed Orkhon Valley Cultural Landscape on World Heritage List, including valuable historical and cultural heritages of human history. Orkhon Valley Cultural Landscape has over 100 cultural sites and about 1350 historical and cultural immovable properties, covering area of 121,967 hectares. Orkhon Valley Cultural Landscape has number of immovable properties selected to state and provincial protection.

“The Law for Protection of Historical and Cultural Properties of 1994” has been revised and changed to “the Law for Protection of Cultural Heritage” by the State Great Khural in 2001. As a result of the past 10 years archeological excavations and research works, the number of cultural properties were discovered, and further protection was required for the preservation of those properties. In accordance with it, the “List for Protection of Historical and Cultural Immovable Properties of State, Province” was revised by the government in 2008. On May 14th of 2008, the protection list has been revised by the 175th resolution of Government, and 175 immovable properties were selected as the state protection, 275 immovable properties are under province protection. 15 immovable properties are included in the state protection. 40 immovable properties are under the state protection, 57 immovable properties under province protection. And for the first time, paleontological sites were selected in the protection list of the state and province.

Protection zone of immovable properties: In Paragraph 6 of article 16, the “Protection law of Historical and Cultural Properties of 1994”, “Government has set up 0.1-3 kilometers of protection zone around the historical and cultural immovable properties, such as remains of ancient cities and settlements, buildings, architecture complexes in order to provide the integrity and safety thereof”. In accordance with this article, setting up protection zones around the immovable properties oversaw their significance on history, culture, science and classification on state protection. By the 241st resolution of Government in 1997, first protection zone was set up around ruins of Kharkhorum city, capital of Mongolian Empire, covering an area of 9.69 square kilometers.

The “Protection law of Historical and Cultural Properties of 1994” revised and changed to “Protection law of Cultural Heritage” by the State Great Khural, in 2001. Paragraphs 6, 7, 8 of article 17, the “Protection law of Historical and Cultural Properties of 1994” re-entered into “Protection Law of Cultural Heritage” and the article for measurement of surrounding areas was removed

- By the 96th decision of 2001, the protection zones were set up around the Gandantegchinlen Khiid monastery, Monastery Geser, Green Palace of Bogd Khaan, Temple of Chojin Lama, Temple of Dambadarjaa, Temple of Dashchoilon (Wooden temples), Apartment of Chin Van Khanddorj.
- By the 71st decision of 2002, protection zones were set up around the inscribed monuments for Bilge Khan, memorial complex of Kültegin in Khashaat soum of Arkhangai province, ruins of Khar Balgas in Khotont soum of Arkhangai province, Tövkhön Monastery in Bat- Ölzii soum of Öwörkhongai province, inscriptions monument of Tonyokuk in Bayan soum of Töv province.
- By the 190th decision of 2003, the protection zones were set up around the complex of deer stone called place of Uushgiin Öwör in Burentogtokh soum of Khövsgul province, ruins of Avarga in Delgerkhaan soum of Khentii province, temple of Manzushir in Töv province, 2 stone columns of monastery Dari-Ekh in Baynzürkh district of Ulaanbaatar city.
- By the 126th decision of 2004, the protection zones were set up around the ruins of Baruun Khüree in Kharkhorin soum of Öwörkhongai province, remains of 2 temples of Khögnö Tarni in Rashaant soum of Bulgan province
- By the 70th decision of 2006, protection zones were set up around the inscriptions monument and building remains of Tsogtiin Tsagaan baishin, ruins of Khar Bukh in Dashinchilen soum of Bulgan province
- By the 123rd decision of 2006, the protection zones were set up around the Orkhon Valley Cultural Landscape as inscribed on World Heritage List, in Arkhangai, Öwörkhongai, Bulgan province
- By the 135th decision of 2009, the protection zones were set up around the paleontological sites of Ergeliin Zoon in Khatanbulag soum Dornogobi province, complex monuments of Öngöt in Altanbulag soum Töv aimag, complex monuments of Ikh Khöshhöt in Delgerkhaan soum Khentii province, complex monuments Öglögchiin Kherem, Rashaan Khad, Üzüür Tshohio in Batshireet soum of Khentii province, Baldan Bereeven temple and rock paintings in Ömnödelger soum of Khentii province, complex monuments of Dund Jargalant, complex of Tsetsen Khan palaces in Kherlen soum of Khentii province, historic building called “Öndör Khorshoo” (recent Fine Art Museum) in Chingeltei District of city Ulaanbaatar, historical building of Central Committee of People’s Party and People’s Government (recent Museum of the History of Ulaanbaatar)
- By the 101st decision of 2011, the protection zone was set up around the monastery Amar bayasgalant in Baruunbüren soum of Selenge province
- By the ... decision of 2011, the protection zone was set up around the Shoroon Bumbagar of Ulaan kherem in Bayannuur soum of Bulgan province
- By the 104th decision of 2012, protection zones were set up around the Sujigtiin am in mountain Noyon in Bornuur soum of Töv province, Zuramt and Juramtyn am in mountain Noyon in Batsumber soum, complex site of Khünnü noble (Xiongnu) in Balgasan tal in Öndör-Ulaan soum of Arkhangai province

Current status and implementation of works of the protection of historical and cultural immovable properties: Many of our historical and cultural immovable properties have already been destroyed by the human activities and natural and weather decays.

Stone monuments are damaged, cracked, disintegrated by water, wind, chemical substances and bacterial damages, which penetrates pores and capillaries of stone. And natural disaster as a quake, fire, water flood, snow and dust storm has damaged stone monuments. Most of the all immovable properties in Mongolia have damaged by water and component became more porous.

Social factors, such as disrespect to culture, urbanization, economic crisis, sparse population, industrialization, illogical policy, irrational planning, religious issues, wrong conservation and protection, human improper activities are damaging historical and cultural heritages.

Recently, physical damages of immovable properties have increased substantially, due to people’s

worship ceremonies. When people worship, they offer and spray milk, butter oil on stones, and wrap them with silk scarf, which have resulted in destruction of these stone monuments.

Today, social behavior has developed disrespect for historical and cultural heritage, people are making illegal excavations to find profits, that also causes destruction and damage for the immovable properties. Also writing letters or drawing images and symbols on ancient rock inscriptions and rock paintings take place.

Since 1940, Mongolia has been organizing number of research and conservation works on protection of immovable properties. In 1944, monastery Erdene Zuu and temple Amarbaysgalant were conserved and restored. In 1960-1961, temple of Chojjin Lama, Green Palace of Bogd Khaan were conserved and restored as well.

In 1971, the “Agency of Academy for Research and Scheme Planning of Historical and Cultural Property” was established in the Central Architectural Institute. In 1973, the “Restoration Laboratory of Historical and Cultural Property” was established under the Ministry of Culture. In 1976, both organizations had united under the name of “Conservation and Restoration Laboratory of Historical and Cultural Property”. Since that time until 1995, the organization have conserved many architectural buildings, such as Erdene Zuu, Amarbaysgalant, Gandantegchinlen, Green Palace of Bogd Khaan, temple of Chojjin Lama, complex of Tsetsen Khan palaces, monastery of Khachin Lama, apartment of Chin Van Khanddorj, historic buildings in Altanbulag relevant to the People’s Revolution etc. Also local administrations have built fences, put introduction boards near the immovable properties for protecting them.

Through 1999-2005, the “National Project for Protection and Conservation of Historical and Cultural Immovable Properties” was implemented, organizing a systematic conservation and preservations of historical and cultural immovable properties.

Within the framework of this project, Center of Cultural heritage and its conservators and specialists have conserved and preserved immovable properties, made copies and replicas of properties for the storage in the state fund, which are of significant historical and scientific value to Mongolians. And in the framework of this project, number of works have been implemented, such as building fences, conserving monastery and temple buildings, setting up lightening arresters etc.

In 2007, the “National Project for Protection and Conservation of Historical and Cultural Immovable Properties” adopted by the 303rd decision of government, for promoting the immovable properties combined with the infrastructure and tourism, and to build capacity of conservators on cultural heritage conservation. The project is planned to be implemented from 2008 till 2015. The work has started. .

Mongolian government is implementing number of works on protection of historical and cultural immovable properties, but it was being destroyed and damaged by the improper activities of people. To stop and prevent this illegal activities on historical and cultural immovable properties, the support of local people is essential.

In the end, we should always remember that our main priority and responsibility is to respect and protect our historical and cultural heritage and pass it on to the future generations.

БУЛГАН АЙМГИЙН НУТАГ ДАХЬ ТҮҮХ, СОЁЛЫН ҮЛ ХӨДЛӨХ ДУРСГАЛЫН ТУХАЙ

Булган аймгийн товч танилцуулга. Булган аймаг нь Монгол орны умард хэсэгт, зүүн талаараа Орхон, Сэлэнгэ аймагтай, зүүн урд талаараа Төв аймагтай, урд талаараа Өвөрхангай аймагтай, баруун талаараа Архангай аймагтай, баруун хойд талаараа Хөвсгөл аймагтай, хойд талаараа ОХУ-ын АБНБУ-тай тус тус хиллэн 48.8 мян.км² газар нутаг эзлэн оршдог. Аймгийн төв нь Булган хот, Улаанбаатар хотоос 318 км зайтай.

Булган аймгийн газар нутаг нь Ардын хувсгалаас өмнө Халхын Түшээт хан аймагт, 1923 оноос Богд хан уулын аймагт тус тус харьяалагдаж байжээ. 1931 оны УБХ-ын Тэргүүлэгчдийн 5 дугаар тогтоолоор Сэлэнгэ аймгийг байгуулахад тус аймгийн ихэнх газар нутаг Сэлэнгэ аймгийн харьяалагдаж байжээ. БНМАУ-ыг Ардын Сайд нарын Зөвлөлийн 1937 оны 33 дугаар тогтоолоор Булган аймгийг шинээр байгуулж Сэлэнгэ аймгаас Сайхан, Хантай, Сэлэнгэ, Булган, Сэлэнгэбүрэн, Хариун, Хангал, Цонхлон сумдыг, Төв аймгаас Бүрэгхангай, Авзага сумдыг, Хөвсгөл аймгаас Тэшиг, Хутаг-Өндөр, Намнан, Баян-Агт сумдыг, Архангай аймгаас Могод сумыг тус тус харьяалуулахаар шийдвэрлэжээ. 1938 онд Сэлэнгэ аймгаас Баруунбүрэн, Орхонтуул сумдыг нэгтгэсэн байна.

Өнөөдөр Булган аймаг нь Баян-Агт, Баяннуур, Бугат, Булган, Бүрэгхангай, Гурванбулаг, Дашинчилэн, Могод, Орхон, Рашаант, Сайхан, Сэлэнгэ, Тэшиг, Хангал, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр, гэсэн засаг захиргааны 16 сум, 49 баг, 1 тосгонтой. Тус аймагт халх ястан зонхилсон 58.5 мянган ард иргэд оршин сууж амьдарч байна.

Булган аймгийн газар нутаг нь эх газрын эрс тэс уур амьсгалтай, өвлийн дундаж температур -19° - -24°С, зуны дундаж температур +14° - +19°С, жилд дунджаар 220-420 мм хур тунадас унадаг. Аймгийн нутаг дэвсгэрийн ихэнх хувийг тайгын цэвдэгт, намгийн цэвдэгт, хар шороо, хар хүрэн, нимгэн хар шороо, татмын, хээрийн хүрэн хөрс зонхилсон уулархаг газрын гадарга эзлэнэ. Аймгийн нутаг дээгүүр Сэлэнгэ, Орхон, Туул, Эг, Зэлтэр, Хануй зэрэг Монгол орны томоохон бүх гол мөрөн урсдаг. Нутгийн хойд хэсэгт Соёны нурууны зүүн захын салбар уулс, баруун, баруун урд хэсэгт Хангайн нурууны салбар уулс оршино. Булган аймгийн нутагт Харгал, Айрхан, Тэшиг, Цэгээн, Шарга гэх мэт том жижиг талбайтай 70 гаруй нуур бий. Түүнчлэн Хунт, Хульж, Хануй, Цагаангол, Чулуут, Хөөвөрийн зэрэг 30 орчим эрдэслэг рашаантай.

Тус аймгийг 1942 онд Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнаж байжээ.

Булган аймгийн нутаг дахь түүх, соёлын дурсгалыг бүртгэж судалсан тухай тойм. Булган аймгийн нутагт орших түүх соёлын дурсгалт зүйлсийг эртнээс шинжлэн судалсан нь тус аймгийн нутагт эртний нүүдэлчдийн үлдээсэн хот балгадын туйр олон байдагтай холбоотой юм. Эдгээр дурсгалаас анх 1870-аад онд Оросын эрдэмтэн А.Падерин одоогийн Дашинчилэн сумын нутагт буй Харбухын балгасыг олж судалснаар энэ бүс нутгийн түүх, соёлын дурсгалт зүйлсийг судлан шинжлэх ажил эхэлсэн ажээ. Үүний дараа буюу XIX зууны сүүлээр Оросын эрдэмтэн Д.Клеменц нар Монгол орноор олон талын судалгаа хийх явцдаа дээрх Харбухын балгас болон Цогтын Цагаан байшин зэргийг үзэж анхны эрдэм шинжилгээний тодорхойлолт бичсэн байна.

1894 онд Георг Хут Цогтын Цагаан байшингийн дэргэд босгосон гэрэлт хөшөөний монгол, төвд бичээсийг герман орчуулгын хамт нийтлүүлсэн бол 1933-1934 онд Оросын эрдэмтэн Д.Д.Букенич уг байшингийн үлдэгдэл орчимд бага хэмжээний малтлага судалгаа хийсэн мэдээ баримт байдаг.

1889 онд Оросын судлаач Н.М.Ядринцев одоогийн Могод сумын нутгаас нэгэн чулуун байгууламж илэрүүлэн олсон нь Хөл Асгат буюу Их асгатын дурсгал хэмээгдэн эрдэм шинжилгээний ном зохиолд нэрлэгддэг эртний түргийн үед холбогдох тахилын онгон байсан бөгөөд анхлан В.В.Радловын “Монголын эртний дурсгалын атлас” хэмээх бүтээлд хэвлэгджээ.

1909 онд Финляндын эрдэмтэн Г.И.Рамстедт Сайхан сумын нутаг Могойн шинэ ус хэмээх газар орших эртний Уйгур улсын хаан Моюнчурын тахилын онгоны цогцолбор болон тус сумын Сүүжийн даваа гэх газраас түрэг бичиг илрүүлэн олж судалжээ. Түүний олж нийтэлсэн Сүүжийн давааны

бичээсийг өнөө хир өөр судлаач олж үзэж чадаагүй байна.

Монгол нутаг дахь Уйгарын соёлын өөр нэг дурсгал бол тэдний барьж үлдээсэн хот суурин, хэрэм бэхлэлтүүд бөгөөд эдгээрийн нэг нь Булган аймгийн Хутаг-Өндөр сумын (Магсаржав сангийн аж ахуйн) нутагт, сумын төвөөс 11 км, Сэлэнгэ мөрний хойд эрэгт орших Бай-балык хот юм. Энэ хэрмийн үлдэгдлийг нутгийн ардууд Бий-булаг хэмээн нэрлэдэг аж. Хэдийгээр уг хотын үлдэгдлийг судлаачид харьцангуй бага судалсан ч сурвалжийн мэдээ занги болон уг хотын үндсэн хэв шинж, түүвэр олдвор дэр үндэслэн он цагийг нь тогтоосон байна.

1920-иод оны сүүлээр ард олноо мэргэн гүн хэмээн алдаршсан М.Гомбожав өнөөгийн Гурванбулаг сумын Гурвалжин уулын энгэрээс түрэг бичгийн дурсгал олсноо хуулан авч Судар бичгийн хүрээлэнгийн дарга Ж.Цэвээндөгчээ. Ж.Цэвээн уг хуулбарыг Оросын эрдэмтэн А.Н.Самойловичид илгээж, тэр нь 1934 онд тайлж уншин хэвлүүлснээр Гурвалжин уулын бичээс эрдэм шинжилгээний эргэлтэд орсон байна.

1948-1949 онд Зөвлөлтийн нэрт археологич С.В.Киселев, Х.Пэрлээ нарын удирдсан “Монгол Зөвлөлтийн хамтарсан хээрийн шинжилгээний анги” Монголын эртний нийслэл Хархорум хотыг малтан шинжлэхийн сацуу Булган аймгийн нутаг орших Харбухын балгасын шороон овгоруудад бага хэмжээний малтлага хийсэн байдаг. Хожим Х.Пэрлээ 1961 онд хэвлүүлсэн “Монгол Ард улсын эрт дундад үеийн хот суурины товчоо” хэмээх бүтээлдээ Булган аймгийн нутагт орших Чин толгой, Эмгэнтийн хэрэм, Дэрсэн хэрэм зэрэг хэд хэдэн эртний хот суурингийн үлдэгдэлийг шинжилсэн үр дүнг оруулжээ.

1950-аад үед Монголын ууган археологчийн нэг Ц.Доржсүрэн Булган аймгийн Баян-Агт, Архангай аймгийн Хайрхан сумын заагт орших Шивээт улаан хэмээх цогцолбор дурсгалыг судлаж VI зууны үед холбогдуулан үзжээ.

1964 онд Польшийн эрдэмтэн Е.Трыярски өмнө нь О.Намнандоржийн мэдээлсэн Хишиг-Өндөр сумын нутагт орших Ар ханангийн түрэг бичээсийн үсэг-зурлагыг тайлан унших судалгаа хийснээ нийтлүүлсэн байна. Мөн энэ бичээсийг хожим нь С.Харжубай, С.Г.Кляшторный, Ц.Баттулга нарын судлаачид судалж нийтлүүлсэн байдаг.

1962-1964 онд “Монгол-Зөвлөлтийн хамтарсан чулуун зэвсгийн үе судлах анги” археологич Н.Сэр-Оджав, Д.Дорж, А.П.Окладников, А.П.Деревянко, В.В.Волков, В.Е.Ларичев нарын бүрэлдэхүүнтэй Архангай, Өвөрхангай, Булган, Төв аймгийн нутагт археологийн хайгуул судалгааны ажил хийж олон арван дурсгалыг давтан болон шинээр илрүүлэн олж бүртгэжээ.

1964 он Н.Сэр-Оджав, Д.Дорж, Болгарын судлаач С.Михайлов нарын бүрэлдэхүүнтэй “Сэлэнгийн шинжилгээний анги” Булган, Сэлэнгэ аймгийн нутгаар археологийн хайгуул, судалгаа хийж Могод, Бугат зэрэг сумдын нутгаас буган чулуун хөшөө, хүн чулуу, дөрвөлжин булш, хиргисүүр зэргийг олж илрүүлэн тодорхойлолт бичжээ.

1966 онд нэрт газарзүйч О.Намнандорж Дашинчилэн сумын Савангийн голын Хангидайн хаднаас эртний сийлмэл зураг, түрэг бичгийн дурсгалыг илрүүлэн олж нийтлүүлсэн бөгөөд түрэг бичээсийг хожим нь Б.Ренчин, Б.Базылхан, М.Шинэхүү, С.Г.Кляшторный, Л.Болд нарын эрдэмтэд судалж нийтлүүлсэн байна.

1970-аад онд МЗТСХЭ-ийн “Палеолит ба нүүдэлчдийн дурсгал судлах анги” Хөвсгөл, Увс, Архангай, Баянхонгор, Булган зэрэг аймагт археологийн малтлага, судалгаа хийж олон тооны дурсгал шинээр илэрүүлэн олжээ. Дээрхи хайгуул, судалгааны дүнд илэрч олсон Дашинчилэн сумын Арслантын хадны зураг, Орхон сумын буган хөшөөд, Баруун Могойн хадны зураг, Бүрэгхангай сумын Шовгор Зараагийн хадны зураг, Бугат сумын Бичигт хадны зосон зураг, Сайхан сумын Асган Дэвсэгийн буган хөшөөд зэрэг хүрэл зэвсгийн олон дурсгалуудыг В.В.Волков, Д.Цэвээндорж нар шинжлэн судлаж өөр өөрсдийн зохиол бүтээлдээ хэвлэн нийтэлсэн байдаг.

1976, 1977, 1979, 1986 онд “МЗТСХЭ-ийн бичээс судлалын анги” Булган аймгийн нутагт хайгуул, судалгаа хийж олон үед холбогдох түүх соёлын дурсгал илрүүлсний зэрэгцээ өмнө илрүүлсэн дурсгалуудыг дахин нягтлан харцуулах зэрэг ажил хийсэн байна.

1983 онд археологич Д.Наваан Бүрэгхангай сумын нутаг, Өвгөнт уулын энгэрт орших эртний нэгэн булш малтаж адууны тоног хэрэглэл, алтан ялтас зэрэг маш сонирхолтой эд өлгийн зүйлс олжээ. Тэрээр уг булшийг хүннүгийн үед холбогдуулан үзэж булшнаас гарсан алтан ялтсан дээрх тамга, тэмдгүүдийг хүннү нарын бичиг үсгийн дурсгал мөн хэмээн үзжээ.

1984 онд Хутаг-Өндөр сумын Тээл хэмээх нэртэй газар МЗТСХЭ-ийн шинжилгээний анги 5 булш малтан шинжилж хүний толгойг умар зүг, нүүрийг баруун тийш хандуулан хөлийг нь атийлгаж, бог малын дал, толгойг дагалдуулсан сонирхолтой зан үйл илрүүлсэн байна.

1987 онд “МЗТСХЭ”-ийн судалгааны анги ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, археологич Д.Наваан, Т.Санжмятав, В.В.Волков нар Ховд, Булган, Архангай аймгийн нутагт олон үед холбогдох булш малтан судалсны зэргэцээ буган чулуун хөшөө, хадны зураг судлан тодорхойлолт бичсэн бөгөөд Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Хантай багийн нутаг Эгийн голын савд хүннүгийн үеийн 2 булш малтан судалж, засаж янзалсан бугын эвэр, ваарны хагархай зэрэг сонирхолтой олдворууд илрүүлсэн аж.

1990 онд ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, археологич Д.Баяр, Х.Лхагвасүрэн нарын бүрэлдэхүүнтэй Булган, Төв, Сэлэнгэ аймгийн нутагт ажилласан хээрийн шинжилгээний анги Сэлэнгэ сумын Ингэт толгойн 1 хүн чулууг үзэн тодорхойлолт хийхдээ нэгэн үе Монгол нутагт ноёрхлоо тогтоож байсан Кидан нарын соёлын дурсгал бололтой хэмээн үзсэн байна.

1993 онд Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Хантай багийн нутаг Эгийн голын сав газарт усан цахилгаан станц барих шалтгаанаар ШУА-ны Түүхийн хүрээлэнгийн судалгааны баг тэр орчмын археологийн дурсгалуудыг авран хамгаалах үүднээс малтан шинжилж эхэлсэн байна. Үүнээс хойш 2000 он хүртэл Франц, АНУ-ын судлаачидтай хамтарсан шинжилгээний ангиуд Эгийн голын савд нийт 251 км² талбайд хайгуулын ажил гүйцэтгэж түүхийн олон үед холбогдох 906 том жижиг дурсгал илрүүлэн олж бүртгэжээ. Үүний дотор чулуун зэвсгийн үеийн 28 бууц, хүрэл зэвсгийн үеийн хиргисүүр 389, дөрвөлжин булш 89, хадны зураг 3, буган чулуун хөшөө 1, хүннү булш 119, түрэг булш 3, дундад зууны үеийн булш 71, хадны оршуулга 1, эртний суурингийн үлдэгдэл 2, шинэ үед холбогдох төвд маанийн үсэгтэй чулуун хөшөө 201, сүм хийдийн турь 5 илрүүлэн судалсан бөгөөд нэг бүс нутгийг цогцоор нь судалсан нь эрдэм шинжилгээний хувьд чухал ажил болосон байна.

1996-1999 онд Г.Гонгоржав, Г.Энхбат нарын бүрэлдэхүүнтэй хээрийн шинжилгээний баг “Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал” сэдэвчилсэн лавлах бүтээх ажлын хүрээнд Булган аймгийн нутагт ажиллаж олон тооны дурсгалыг давтан болон шинээр бүртгэж, гэрэл зураг, гар зураг, дүрс бичлэгээр баримтжуулсан байдаг. Тэдний цуглуулсан үл хөдлөх дурсгалтай холбоотой мэдээ баримт, эх хэрэглэгдэхүүн эдүгээ СӨУНБМС-д хадгалагдаж байна.

1998 онд Монгол-Японы хамтарсан “Бичээс” төслийн судалгааны анги Дашинчилэн сумын нутагт орших Цогтын Цагаан байшингийн гэрэлт хөшөөний Монгол бичээс болон тус сумын нутагт орших Туул голын Бичигт шургуулга гэх газар орших Монгол, түвд, самгарьд, нанхиад бичээсүүдийг давтан судлаж нийтлүүлжээ.

1999 онд “Монгол-Францын хамтарсан палеолитын хээрийн шинжилгээний анги” Хутаг-Өндөр сумын нутагт хайгуул судалгаа хийж олон үеийн соёлт давхарга бүхий палеолитын сууринг шинээр нээн илрүүлж дараа жилээс нь Дөрөлж I, II сууринд малтлага судалгаа хийжээ.

2000 он ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, археологич Ч.Ерөөл-Эрдэнэ Бүрэгхангай сумын нутаг Орхон голын хөндийд усан цахилгаан станц барих талбайд археологийн урьдчилсан хайгуул судалгаа хийж нийтдээ 60 орчим эртний булш, хиргисүүр, бичээс, хадны зураг тус бүр 1, төвд бичээстэй хөшөө чулуу 2 зэрэг түүх соёлын дурсгалт зүйлс илэрснийг газрын зурагт тэмдэглэн тодорхойлолт бичсэн байна.

2001 онд Дашинчилэн сумын нутаг Харбухын голын баруун эрэгт Монгол-Бельгийн хамтарсан судалгааны баг дөрвөлжин хүрээтэй хиргисүүр малтан судлахад талийгаачийг газрын хөрсөн

дээр толгойг баруун тийш хандуулан тэнэгэр байдалтайгаар хэвтүүлэн тавьж шууд чулуугаар дарж оршуулсан байжээ. Энд оршуулгын ямар нэгэн эд өлгийн зүйл илрээгүй боловч дараас чулууны дундаас маш сайн хадгалагдсан хүрэл ойл олджээ.

2002 оноос “Хар бух” нийгэмлэгийн санхүүжилтээр ШУА-ийн Түүхийн хүрээлэн, Археологийн хүрээлэн хамтран Дашинчилэн сумын нутагт орших Харбухын балгасанд дахин малталт шинжилгээ явуулж судалгааны олон чухал хэрэглэгдэхүүн илрүүлсний зэргээс уг балгасыг Хятан улсын үед баригдсан болохыг баттай тогтоожээ.

Мөн түүнчлэн тус сумын нутаг дахь Чин толгойн балгасанд 2004 оноос эхлэн Монголын Үндэсний музей, Нүүдлийн Соёл Иргэншил Судлах Олон Улсын хүрээлэн, ОХУ-ын ШУА-ын Сибирийн салбарын Монгол, Түвд, Буддын судлалын хүрээлэн хамтран малталт судалгаа явуулан эртний бичиг үсгийн холбогдолтой чухал олдворуудыг олж нийтлүүлжээ.

2002 онд Монгол-Орос-Америкийн хамтарсан чулуун зэвсгийн судалгааны экспедици Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Уныт багийн нутаг Төлбөрийн голын дагуу нарийвчилсан хайгуул хийж хуучин чулуун зэвсгийн үеийн 19 бууц сууринг олж илрүүлсэн бөгөөд 2006 оноос Монгол-Оросын хамтарсан чулуун зэвсгийн судалгааны анги Төлбөрийн голын 4-р сууринд археологийн малтлага судалгааны ажил хийж байна.

2009 онд профессор А.Очир ахлагчтай Монгол-ОХУ-ын хамтарсан археологийн судалгааны баг Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт орших Эмгэнтийн хэрмэнд Х.Пэрлээгийн малтлагыг үргэлжлүүлэн судалгаа хийж Монгол нутгаас илэрч олдож байгаагүй бүтэц, зохион байгуулалттай Хятаны үеийн хэрэм болохыг тогтоожээ.

2011 онд профессор А.Очир, С.Харжубай нарын удирдсан Монгол-Казакстаны хамтарсан хээрийн шинжилгээний анги Булган аймгийн Баяннуур сумын нутаг Улаан хэрмийн дэргэдэх Шороон бумбагар хэмээх дурсгалыг малтан судалж эртний Уйгар угсаатны түүхэнд холбогдох ханын зураг бүхий онц сонирхолтой бунхант булшиг илрүүлжээ. Энэхүү ханын зураг нь Монгол төдийгүй, Төв Азийн түүхэнд анх удаа олдож байгаагаар тун ховор үнэ цэнэтэй дурсгал болох юм. Бунхнаас гарсан 550 гаруй олдвор болон ханын зургийг судлах хамгаалах, сэргээн засварлах, олон нийтэд сурталчилах, аялал жуулчлалын бүтгээгдэхүүн болгох зэрэг ажлыг БСШУЯ-ны дэмжлэгтэйгээр холбогдох байгууллагууд шат дараатай авч хэрэгжүүлж эхлээд байна.

2011 онд ШУА-ын Археологийн хүрээлэнгийн судлаачид АНУ-ын Йелийн их сургуультай хамтран Булган аймгийн Тэшиг сумын нутагт археологийн хайгуул, малтлага судалгаа хийж олон тооны дурсгалыг давтан болон шинээр илрүүлэн судалжээ.

Дээр тоймлон дурдсан судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд өнөөгийн Булган аймгийн нутаг дахь түүх, соёлын дурсгалын талаарх мэдээллийн сан бүрдэж байна. Цаашид энэ ажил өргөжин тэлж тус аймгийн нутаг дахь түүх, соёлын дурсгалын сан хөмрөгийг улам бүр баяжуулж, хүн төрөлхтний түүхэнд эзлэх байр суурийг өргөх нь дамжиггүй юм.

Булган аймгийн нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалт. Булган аймгийн нутаг дэвсгэр дээрх үл хөдлөх дурсгалаас 1941 оны УБХ-ын Тэргүүлэгчдийн 79 дүгээр хурлаас батлан гаргасан “улсын хамгаалалтад авах дурсгал”-ын дотор Бүрэгхангай сумын нутагт орших /өнөөгийн Булган аймгийн Баяннуур, Дашинчилэн сумдын зааг/ Туулын Цагаан байшин, мөн суманд орших Чин толгойн балгас, Харбухын хар балгас буюу Хунтайжийн балгас гэсэн гурван дурсгал орсон байдаг. Харин БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл /СнЗ/-ийн 1971 оны 420 дугаар тогтоолоор баталсан “Улс, орон нутгийн хамгаалалтад авсан түүх, соёлын дурсгалын жагсаалт”-ын улсын хамгаалалтад:

- Могод сумын нутагт орших Түрэг бичээстэй хөшөө
- Сайхан суманд орших булшны уйгар бичээс
- Дашинчилэн сумын Цогт тайжийн балгас ... гэсэн 3 дурсгалыг

орон нутгийн хамгаалалтын жагсаалтад:

- Булган хотод орших штабын байшин
- Булган хотод орших Улсын баатар С.Лхагвадоржийн хөшөө
- Булган хотод орших Тамгын овоон дээрх Харуулын цамхаг
- Сайхан сумын Шинэ ус гэх газар орших Түрэгийн гэрэлт хөшөө ... гэсэн 4 дурсгалыг тус тус оруулан баталсан байдаг.

Булган аймгийн АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны 1978 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 15 дугаар тогтоолоор баталсан сум, хороо, хотын АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны хамгаалалтад байх түүх, соёлын дурсгалт зүйлийн жагсаалтад сумдын нутагт орших эртний булш, хөшөө чулуу, сүм хийдийн туйр, түүхэн барилга байшин зэрэг дурсгалуудыг хамруулж хамгаалалтад авчээ. Уг жагсаалтад:

- Гурванбулаг сумын МАХН-ын анхны үүр байгуулсан Очирт орон гэдэг газар
- Хишиг-Өндөр суман дахь БНМАУ-ын Хөдөлмөрийн баатар З.Очирын дурсгалын самбар, Дух нарс, Дүгэрээ нарс, Гуртын тавилан дахь дурсгалын самбарууд
- Гурванбулаг сумын Хөгнө хааны Өвгөн хийдийн балгас, Цогт тайжийн харуулын шивээ
- Могод сумын Дулаанхаан уулын Битүү байшинт
- Бүрэгхангай сумын Бичигтийн хадны бичээс
- Хишиг-Өндөр сумын хойд талд байгаа бугын чулуун хөшөө, Ингэттолгойн САА-н төвд байгаа Далх Вандад гэдэг эртний бөөгийн мөргөлийн үеийн баатрын чулуун хөрөг хөшөө
- Орхон сумын нутаг Сээрийн голын адаг дахь бугын чулуун хөшөө
- Дашинчилэн сумын Харбухын голын хийдийн балгас, Чин толгой, түүний өвөр дэх Кидан улсын хэрэм
- Хутаг-Өндөр сумын нутаг дахь Уйгар улсын Бай-Балык буюу Бий-Булагийн балгасын хэрмийн турь, Нарийн Төлбөрийн бичигт хад ... гэсэн дурсгалыг хамгаалалтад авсан байна. Энэхүү тогтоолд дурсгалуудын холбогдох он цаг, оршин буй газрын нэр, харьяалах сум, бригадын нэр зэргийг буруу зөрүү бичсэн цөөнгүй алдаа мадаг байдаг хэдий ч анх удаа өөрийн нутаг дээрх дурсгалуудаа хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн чухал шийдвэр болсныг дурдууштай.

1994 онд УИХ-аас “Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль”-ийг батлан гаргасны дараа Засгийн газрын 1994 оны 233 дугаар тогтоолоор хуучин СнЗ-ийн 1971 оны 420 дугаар тогтоолыг шинэчлэн “Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт” нэрээр баталжээ. Энэ тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-д Булган аймгийн нутаг дахь үл хөдлөх дурсгалаас улсын хамгаалалтад:

- Могод сумын Хөл-Асгалт гэдэг газар орших Түрэгийн Алтан тамган дархны бичигт хөшөө
- Дашинчилэн сумын Халдунзүрх ууланд орших Цогт хун тайжийн балгас, бичигт хөшөө
- Орхон сумын нутагт орших 7 ширхэг буган хөшөө, хиргисүүрийн цогцолбор
- Сайхан сумын нутагт орших 8 ширхэг буган хөшөө бүхий дөрвөлжин булш
- Дашинчилэн сумын нутагт орших Хар бухын балгас ... гэсэн 5 дурсгалыг,

аймгийн хамгаалалтад:

- Рашаант сумын Хөгнөхаан ууланд орших Хөгнөхааны их, бага хийдийн туйр
- Хутагт сумын нутагт орших Бий булагийн балгас
- Дашинчилэн сумын нутагт орших Чинтолгойн балгас
- Бугат сумын Хужиртын голын хөндийд орших Бичигтийн хадны зураг
- Булган хотод орших Баруун замын байлдааны штабын байшин
- Булган хотын Тамгын толгойд орших Хатанбаатар Магсаржавын дуулгат бунхан
- Орхон сумын Сээрийн адаг гэдэг газар орших буган чулуун хөшөө
- Сайхан сумын Нарийн Хүрмийн Хөшөөн дэвсгэг гэдэг газар орших хүн чулуу
- Сэлэнгэ сумын Ингэттолгойд орших “Далхбандид” гэгдэх хүн чулуу

- Хутаг сумын Нарийн Төлбөрийн Бичигт бэржин гэдэг газар орших бичигт хад
- Хутаг сумын Нарийн Төлбөрийн адаг гэдэг газар орших буган чулуун хөшөө
- Хутаг сумын Гуртын гүүр, Усны-Арал гэдэг газар орших хүн чулуу
- Булган сумын Зүүнтүрүү гэдэг газар орших хүн чулуу
- Булган сумын төвд орших Диваажин хэмээх сүмийн үлдэгдэл
- Могод сумын Цахиуртай гэдэг газар орших буган чулуун хөшөө
- Баян-Агт сумын Халтар гэдэг газар орших 3 ширхэг буган чулуун хөшөө
- Орхон сумын төвд орших 4 ширхэг буган чулуун хөшөө
- Баян-Агт сумын Шивээт-Улаан гэдэг газар орших хүн чулууны цогцолбор
- Бугат сумын Хужиртын голын хөндийд орших бичигт хад
- Бүрэгхангай сумын Бичигтийн хадны хошуунд орших бичигт хад
- Гурванбулаг сумын Авзагахайрхан гэдэг газар орших сүг зурагтай хад
- Дашинчилэн сумын Лах уул, Арслант гэдэг газар орших сүг зурагтай хад
- Дашинчилэн сумын Лах уул, Хангидай гэдэг газар орших сүг зурагтай хад
- Булган хотын Майдарын голын хөндийд орших Цагаан сувраганы туйр
- Могод сумын Улаан хаалга гэдэг газар орших сүг зурагтай хад
- Сайхан сумын Асган дэвсэг гэдэг газар орших бичигт хад
- Сайхан сумын Асган дэвсэг гэдэг газар орших буган чулуун хөшөө
- Сайхан сумын Нарийн хүрэмт гэдэг газар орших бичигт хад
- Сайхан сумын Нарийн хүрэмт гэдэг газар орших буган чулуун хөшөө
- Хишиг-Өндөр сумын Мааньт гэдэг газар орших буган чулуун хөшөө
- Хишиг-Өндөр сумын Арханан гэдэг газар орших Түрэг бичээс
- Тэшиг сумын хуучин төвд орших буган чулуун хөшөө ... гэсэн 32 дурсгалыг тус тус оруулжээ.

1995-1998 онд УИХ-аас “Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль”-д зарим өөрчлөлт оруулж шинээр аймаг, сум байгуулсан, археологийн хайгуул, малтлага судалгааны үр дүнд хамгаалалтад оруулах шаардлагатай дурсгалууд шинээр илэрч олдсон зэрэг шалтгааны улмаас 1994 онд баталсан “Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-ыг шинэчлэх шаардлага урган гарч ирсэн байна. Энэ шаардлагыг харгалзан Монгол улсын Засгийн газар 1998 оны 235 дугаар тогтоолоор “Улс аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-ыг шинэчлэн баталжээ. Уг жагсаалтад Булган аймгийн нутаг дэвсгэрт орших үл хөдлөх дурсгалаас улсын хамгаалалтад:

- Баян-Агт сумын Шивээт-Улаан гэдэг газар орших хүн чулууны цогцолбор
- Дашинчилэн сумын Халдунзүрх ууланд орших Цогт тайжийн Цагаан байшингийн балгас, бичигт хөшөө
- Дашинчилэн сумын нутагт орших Хар бухын балгас
- Дашинчилэн сумын нутагт орших Чин толгойн балгас
- Могод сумын Хөл-Асгат гэдэг газар орших Түрэгийн Алтан тамган дархны бичигт хөшөө
- Сайхан сумын Байширын ус гэдэг газар буй буган хөшөө бүхий цогцолбор
- Сайхан сумын Могойн гол, Шинэ-Ус нуурын зүүн тал, Хиргист хөндийн аманд орших Уйгарын Моюунчурын гэрэлт хөшөө
- Хутаг-Өндөр сумын нутагт орших Бийбулагийн балгас ... гэсэн 8 дурсгалыг,

аймгийн хамгаалалтад:

- Баян-Агт сумын Халтар гэдэг газар орших 3 ширхэг буган чулуун хөшөө
- Бугат сумын Хужиртын голын хөндийд орших Бичигтийн хадны зураг, бичигт хад
- Булган хотын Майдарын голын хөндийд орших Цагаан сувраганы туурь
- Булган сумын Зүүнтүрүү гэдэг газар орших хүн чулуу
- Булган сумын төвд орших Диваажин хэмээх сүмийн үлдэгдэл
- Бүрэгхангай сумын Бичигтийн хадны хошуунд орших бичигт хад
- Гурванбулаг сумын Авзага хайрхан гэдэг газар орших сүг зурагтай хад
- Гурванбулаг сумын Гурвалжин уулын Түрэг бичээс
- Дашинчилэн сумын Лах уул, Арслант гэдэг газар орших сүг зурагтай хад
- Дашинчилэн сумын Бүдүүний нурууны Хангидай гэдэг газар орших сүг зурагтай хад

- Могод сумын Цахиуртай гэдэг газар орших буган чулуун хөшөө
- Могод сумын Улаан хаалга гэдэг газар орших сүг зурагтай хад
- Орхон сумын Сээрийн адаг гэдэг газар орших 7 ширхэг буган чулуун хөшөө
- Рашаант сумын Хөгнө хаан ууланд орших Хөгнө хааны их, бага хийдийн туйр
- Сайхан сумын Нарийн хүрмийн Хөшөө дэвсэг гэдэг газар орших хүн чулуу
- Сайхан сумын Их Хүрэмтийн Асган дэвсэг гэдэг газар орших буган чулуун хөшөө
- Сайхан сумын Нарийн хүрэмт гэдэг газар орших бичигт хад
- Сэлэнгэ сумын Ингэттолгойд орших “Далхбандид” гэгдэх хүн чулуу
- Тэшиг сумын хуучин төвд орших буган чулуун хөшөө
- Хишиг-Өндөр сумын төвийн хойд талд орших буган чулуун хөшөө
- Хишиг-Өндөр сумын Арханан гэдэг газар орших Түрэг бичээс
- Хутаг-Өндөр сумын Нарийн төлбөрийн Бичигт бэржин гэдэг газар орших бичигт хад
- Хутаг-Өндөр сумын Нарийн төлбөрийн адаг гэдэг газар орших буган чулуун хөшөө
- Хутаг-Өндөр сумын Гуртын гүүр, Усны-арал гэдэг газар орших хүн чулуу
- Хутаг-Өндөр сумын Хантай багийн нутагт орших Бичигтийн үзүүрийн хадны зураг
- Хутаг-Өндөр сумын нутагт орших Эгийн голын олон үеийн цогцолбор дурсгал ... гэсэн

26 дурсгалыг оруулжээ.

Монгол улсын Засгийн газрын 2008 оны 175 дугаар тогтоолоор батлагдсан “Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-ыг сүүлийн 10 гаруй жилийн туршид шинээр илэрч олдсон олон арван дурсгалаар баяжуулан шинэчлэн баталсан юм. Булган аймгийн нутаг дахь үл хөдлөх дурсгалаас уг жагсаалтын улсын хамгаалалтад:

- Баян-Агт сумын Шивээт-Улаан гэдэг газар орших Түрэгийн үеийн цогцолбор дурсгал
- Дашинчилэн сумын Халдунзүрх ууланд орших Цогтын Цагаан байшингийн балгас, гэрэлт хөшөө
- Дашинчилэн сумын нутагт орших Харбухын балгас
- Дашинчилэн сумын нутагт орших Чин толгойн балгас
- Могод сумын Хөл Асгат гэдэг газар орших Түрэгийн Алтан тамгат дархны бичигт хөшөө
- Сайхан сумын Байширын ус гэдэг газар орших буган чулуун хөшөө
- Сайхан сумын Хиргист хөндийн аманд орших Уйгарын Моюунчурын гэрэлт хөшөө
- Сэлэнгэ сумын Ингэт толгойд орших “Далхабандида” гэдэг хүн чулуун хөшөө
- Хутаг-Өндөр сумын нутагт орших Бийбулагийн балгас
- Хутаг-Өндөр сумын Төлбөрийн голын сав дагуух чулуун зэвсгийн суурин, эртний булш, хиргисүүрүүд ... гэсэн 10 дурсгалыг,

аймгийн хамгаалалтад:

- Баян-Агт сумын Халтар гэдэг газар орших буган чулуун хөшөөнүүд
- Бугат сумын Хужиртын голын хөндийд орших Бичигтийн хадны зураг, бичээс
- Булган сумын Майдарын голын хөндийд орших Цагаан суварга
- Булган сумын Зүүн түрүү гэдэг газар орших хүн чулуун хөшөө
- Булган сумын төвд орших Диваажингийн сүмийн туйр
- Бүрэгхангай сумын Бичигтийн хадны хошуунд орших хадны бичиг
- Гурванбулаг сумын Авзага хайрхан ууланд орших хадны зураг
- Гурванбулаг сумын Гурвалжин уулын түрэг бичээс
- Дашинчилэн сумын Лах уул, Арслант гэдэг газар орших хадны зураг
- Дашинчилэн сумын Бүдүүний нурууны Хангидай гэдэг газар орших хадны зураг
- Могод сумын Цахиуртай гэдэг газар орших буган чулуун хөшөө
- Могод сумын Улаан хаалга гэдэг газар орших хадны зураг
- Орхон сумын Сээрийн адаг гэдэг газар орших 7 ширхэг буган чулуун хөшөө
- Рашаант сумын Хөгнө хан ууланд орших Хөгнө ханы их, бага хийдийн туурь
- Сайхан сумын Нарийн хүрмийн Хөшөөн дэвсэг гэдэг газар орших хүн чулуун хөшөө
- Сайхан сумын Их Хүрэмтийн Асган дэвсэг гэдэг газар орших буган чулуун хөшөө
- Сайхан сумын Нарийн Хүрэмт гэдэг газар орших хадны бичээс
- Тэшиг сумын хуучин төвд орших буган чулуун хөшөө
- Хишиг-Өндөр сумын төвийн хойд талд орших буган чулуун хөшөө

- Хишиг-Өндөр сумын Ар ханан гэдэг газар орших түрэг бичээс
- Хутаг-Өндөр сумын Нарийн төлбөрийн Бичигт бэржин гэдэг газар орших хадны бичээс
- Хутаг-Өндөр сумын Нарийн төлбөрийн адаг гэдэг газар орших буган чулуун хөшөө
- Хутаг-Өндөр сумын Гуртын гүүр, Усны арал гэдэг газар орших хүн чулуун хөшөө
- Хутаг-Өндөр сумын Бичигтийн үзүүр гэдэг газар орших хадны зураг
- Хутаг-Өндөр сумын Эгийн голын хөндий дэх олон үеийн цогцолбор дурсгал ... гэсэн 25

дурсгалыг тус тус хамгаалалтад авчээ.

Сүүлийн жилүүдэд түүх, археологи, угсаатны зүйн судалгаа гадаадын өндөр хөгжилтэй орнуудын туслалцаа дэмжлэгтэйгээр тогтмолжиж байгаатай холбоотойгоор Сэлэнгэ аймгийн нутаг дахь үл хөдлөх дурсгалуудыг шинээр илрүүлэх, судалж шинжих ажил өргөжин тэлсээр байна. Энэ ажлын үр дүнд тус аймгийн нутгаас үнэ цэнэ, ач холбогдол нь бүс нутгийн хэмжээнд үнэлэгдэхээр олон арван дурсгал шинээр олдож төрийн хамгаалалтад орох нь эргэлзээгүй юм.

Монгол улсын Засгийн газрын 1998 оны 51 дүгээр тогтоолоор батлагдан гарсан “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах Үндэсний хөтөлбөр”-ийн 2.4-т Булган аймгийн Рашаант сумын нутагт орших Хөгнө Тарнын хөгшин хийд, Хутаг-Өндөр сумын Бийбалык балгас, Дашинчилэн сумын Хар бухын балгас, Булган сумын Майдарын голын хөндийд орших Цагаан сувраганы үлдэгдэл зэрэг дурсгалыг, консерваци хийж, бэхжүүлж хамгаалахаар, Могод сумын Түрэгийн үеийн Алтан тамган дарханы бичигт хөшөө, Сэлэнгэ сумын Ингэт толгойн хүн чулуу зэрэг дурсгалыг хашаа саравч, аянга зайлуулагчтай болгохоор, Баян-Агт сумын Шивээт-Улааны цогцолбор дурсгалаас зөөгдсөн амьтны дүрст дурсгалуудыг анхны байранд нь байрлуулахаар, Могод сумын Хөл Асгатын Түрэгийн Алтан тамганы дархны бичигт хөшөө, Хишиг-Өндөр сумын Ар ханангийн түрэг бичээсээс хуулбар болон хэв авч Түүх, соёлын дурсгалт зүйлийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд хадгалахаар, Баян-Агт сумын Шивээт Улааны хүн чулуун цогцолборыг түүх, соёлын дурсгалт газар болгон хамгаалалтад авахаар тус тус оруулсан байна. Дээр дурдсан ажлуудын ихэнх нь хэрэгжсэн боловч зарим нэг ажлуудын төсөв зардал, хүн хүч, цаг хугацааг буруу тооцоолсноос болж хэрэгжиж амжаагүй юм.

Дээр дурдсан хөтөлбөрийг олон агуулгаар баяжуулан цаашид дэс дараатай үргэлжлүүлэхийн тулд Засгийн газрын 2007 оны 303 дугаар тогтоолоор шинээр боловсруулсан “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр”-ийг батлан гаргасан юм. Энэ хөтөлбөрт Булган аймгийн Баян-Агт сумын Шивээт-Улааны дурсгал, Дашинчилэн сумын Цогтын Цагаан байшингийн туйр, мөн сумын Хар бухын балгас зэрэг дурсгалыг бэхжүүлж хамгаалахаар, Могод сумын Хөл Асгатын дурсгалаас хэв, дардас авах, хуулбар хийхээр, Сайхан сумын Моюнчурын гэрэлт хөшөөг унаган газраас нь Улаанбаатар хотод зөөж авчирч хадгалахаар тус тус оруулсан байна. Дээрх ажлуудын ихэнх нь тогтоосон цаг хугацаандаа бүрэн хэрэгжсэн бол олон жил дамнан хийгдэхээр төлөвлөгдсөн ажлууд нь эхнээсээ хэрэгжиж эхлээд байна.

2010 оны үл хөдлөх дурсгалын тооллого, бүртгэлийн ажлын тухай. Соёлын өвийн төвийн мэргэжилтэн судлаачдаас бүрдсэн хээрийн шинжилгээний баг Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг тоолж, бүртгэн баримтжуулах ажлынхаа хүрээнд 2010 оны 7 дугаар сарын 05-наас 7 дугаар сарын 30 мөн оны 8 дугаар сарын 30-аас 9 дүгээр сарын 15-ныг хүртэлх хугацаанд Булган аймгийн 16 сумын нутагт ажиллалаа. Бид тус аймгийн нутагт нийт 8500 орчим км зам туулан 237 дурсгалт газрын 8000 гаруй нэгж ширхэг дурсгалыг давтан болон шинээр олж бүртгэн, тэдгээрийг 9753 ширхэг дижитал гэрэл зураг, 354 ширхэг негатив хальсны зураг, 54 гар зураг, 363 минутын дүрс бичлэгээр тус тус баримтжууллаа.

Бид Булган аймгийн нутагт ажиллахдаа сум орон нутгийн холбогдох хүмүүстэй хамтран ажиллах замаар бүртгэл мэдээлэл, хадгалалт хамгаалалт, хяналт шалгалтын талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, зарим орон нутгийг судлах танхим, музейд неолитын үед холбогдох чулуун зэвсгийн цөөнгүй дээжийг хүлээлгэн өгч сан хөмрөгийг нь баяжууллаа.

Булган аймгийн нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг тоолж, бүртгэн баримтжуулах ажлыг хөдөө орон нутагт зохион байгуулахад дэмжин тусалж хамтран ажилласан Булган аймгийн музей, сумдын ИТХ, ЗДТГ, Соёлын төвийн хамт олон, Байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагч, малчид, ард иргэддээ баярласан талархаснаа илэрхийлье.

HISTORICAL AND CULTURAL IMMOVABLE PROPERTIES IN BULGAN PROVINCE

Introduction of Bulgan province. Bulgan province is located in northern part of Mongolia, bordering with Orkhon and Selenge province to the east, with Töv province to the southeast, with the Övörkhangai province to the south, with the Arkhangai province to the west, with the Khövsgöl province to northwest, with the Buryat Republic of Russian Federation, covering 48.8 thousand sq kms. Bulgan is capital of Bulgan province, located 318 kms from Ulaanbaatar city.

Prior to the People's Revolution, the territory of Bulgan was a part of Khalkhyn Tüsheet Khan aimag (province) and since 1923, the province was part of Bogd Khan Mountain province. While establishing the Selenge province in 1931 by the decision of the 5th conference of Presidium of State Baga Khural, almost all territory of province was part of Selenge province. By the 33rd decision of Council of Ministers of Mongolia in 1937, the Bulgan province has new established and Saikhan, Selenge, Bulgan, Selengebüren, Khaliun, Khangal, Tsonkhlon soums of Selenge province, Büreghangai, Avzaga soums of Töv province, Teshig, Khutag-Öndör, Namnan, Bayan-Agt soums of Khövsgöl province, Mogod soum of Arkhangai province were transferred to this province. After in 1938, the Baruunbüren and Orkhontuul soums of Selenge province were united to Bulgan province.

Today Bulgan province has 1 village, 49 baghs (smallest administrative unit), 16 soums (small administrative unit) Bayan-Agt, Bayannuur, Bugat, Bulgan, Büreghangai, Gurvanbulag, Dashinchilen, Mogod, Orkhon, Rashaant, Saikhan, Selenge, Teshig, Khangal, Khishig-Öndör and Khutag-Öndör. It has a population of 58.5 thousand, having predominance of khalkh ethnic group.

Bulgan province has an extreme continental climate with long, cold winters and short summers. The average winter temperature falls between -19°C and -24°C. In summer it rises between +14°C and +19°C. The average rainfall can be between 220 mm and 420 mm. Most of the territory is mountainous, consisting of permafrost, boggy frozen, chernozem, dark brown, flood-plain, sandy, brown types of soil. This province has some biggest rivers of Mongolia, such as Selenge, Orkhon, Tuul, Eg, Zelter and Khanui. As well as, branches of Sayan range located in the north and branches of Khangai range located in the west and southwest of territory. Over 70 big and small lakes are located at territory of province, such as Khargal, Airkhan, Teshig, Tsegeen and Sharga etc. In addition, about 30 springs and minerals are located, such as Khunt, Khulij, Khanui, Tsagaangol, Chuluut and Khöövör etc.

Bulgan province awarded by Order of the Red Banner of labour Valour in 1942.

Research and registration work on immovable properties of Bulgan province. A number of ruins and settlements are located in territory of province, relevant with this historical and cultural properties of Bulgan province were examined since the ancient time. The first examination of historical and cultural properties of Bulgan province was started in 1870's, while Russian academician A.Paderin working in Dashinchilen soum and discovered the ruin of Kharbukh. End of the 20th century, Russian academician D.Klements while carrying out multiple examination in Mongolia made first scientific definitions of ruin Kharbukh and Tsogt's white house.

In 1894, the Mongolian and Tibetan inscriptions at monument of Tsogt's white house were translated into German and published by Georg Khut. In 1933-1934, the Russian academician D.D Bukinich has carried out primary examination and excavation around of this house.

Later, the Russian academician N.M Yadrintsev has discovered ancient Turkish sacrificial stone structure from territory of Mogod soum (recent), which noted in the research books and resources as Khöl Asgat or Ikh asgat. This sacrificial stone structure was first published in the "Atlas of Mongolian antiquities" by W.W Radloff.

In 1909, Finnish academician G.I Ramstedt has discovered and examined the sacrificial complex monument of Uighur khaan Moyunchur from place called Mogoin shine us and ancient Turkish inscriptions from place called Süüjiin davaa in territory of Saikhan soum. Examiners and scholars could not find the inscriptions of Süüjiin davaa until today, discovered and published by him.

Another one cultural property remained by Uighurs in territory of Mongolia is ancient city, settlement

and wall. The ruin of ancient city Bai-balyk is located north bank of the lake Selenge, 11 kms far from center of Khutag-Öndör soum (state farm of Magsarjav) of Bulgan province. Local people called this city as Bii-bulag. However, this city has examined not so much, scholars and examiners have determined its location area, as well as they considered this city belong to Uighurs.

End of 1920's, M.Gombojav who was most respected in people as Mergen gün has found Turkish inscription from mountain Gurvaljin in Gurvanbulag soum and he had sent copy of this inscription to J.Tseveen who was director of Institute of Language and Literature. Director J.Tseveen has sent this copy to the Russian academician A.N Samoilovich and in 1934, the inscription of mountain Gurvaljin has translated and published.

In 1948-1949, S.V Kisyeev and Kh.Perlee archeologists of Mongolian and Soviet joint research team have examined and excavated Mongolian ancient capital Kharkhorum, besides that they have carried out primary excavations to the ancient tombs around of ruin Kharbukh located at territory of Bulgan province. Later, archeologist Kh.Perlee has published his survey outcomes in his book *Mongol Ard Ulsyn ert, Dundad Üeiin Khot Suuriny Tovchoon* or [A Brief History of Ancient and Medieval Period Settlements in the Mongolian People's Republic] in 1961, which carried out on several walls of Chin tolgoi, Emgent and Dersen in Bulgan province.

In 1950's, senior archeologist Ts.Dorjsuren has examined the complex monument Shiveet ulaan located at borderline of Bayan-Agt soum of Bulgan province and Khairkhan soum of Arkhangai province, and he had defined this complex monument belong to 6th century.

In 1964, the Poland academician E.Triyarski has published his survey on decipherment of the Turkish inscription at place called Ar khanan in Khishig-Öndör soum, which was mentioned by O.Namnandorj in before. Later, scholar S.Karzhaubai, S.G.Klyashtornoy and Ts. Battulga have examined and published this inscription.

In 1962-1964, the Mongolian and Soviet joint research team for stone tool including N.Ser-Odjav, D.Dorj, A.P Okladnikov, A.P Derevyanko, V.V Volkov and V.E Larichev have carried out archeological examination in territory of Arkhangai, Övörkhongai, Bulgan, Töv provinces and registered newly and by repeated number of immovable properties.

In 1964, the "Research team of Selenge" including Mongolian archeologist N.Ser-Odjav, D.Dorj, Bulgarian scholar S.Mikhailov have carried out archeological examination in territory of Bulgan, Selenge provinces. As a result of the examination, they have discovered deer stone, man stone, square tomb, tumulus from Mogod and Bugat soum of Bulgan province and wrote definitions of them.

In 1966, Mongolian most respected geographer, researcher O.Namnandorj has discovered and published the ancient engraved petroglyph and Turkish inscriptions from rock Khangidai in river Savan of Dashinchilen soum. Later, academician B.Renchin, B.Bazykhan, M.Shinekhüü, S.G.Klyashtornoy and L.Bold have examined that Turkish inscription and published in their articles.

In 1970's, research team for studies of paleolithic and nomadic heritage of Mongolian and Soviet historical and cultural joint expedition has carried out archeological examination and excavation in Khövsgöl, Uvs, Arkhangai, Bayankhongor, Bulgan provinces. As a result of this examination, number of Bronze Age properties such as petroglyph of Arslantyn khad in Dashinchilen soum, deer stones at Orkhon soum, petroglyph of Baruun Mogoi in Orkhon soum, petroglyph of Shovgor Zaraa in Büregkhongai soum, ochre petroglyph of Bichigt khad in Bugat soum, deer stones of Asgan Devseg in Saikhan soum were discovered from territory of Bulgan province and examined and published by V.V Volkov and D.Tseveendorj.

In 1976, 1977, 1979, 1986, the research team for inscription studies of Mongolian and Soviet historical and cultural joint expedition has organized survey in territory of Bulgan province and discovered numerous historical and cultural properties belong to periods of history. Besides that, the team has done comparably and repeatedly examination on before discovered properties.

In 1983, archeologist D.Navaan has excavated the ancient tomb at place called Övgönt in Büregkhan-

gai soum and discovered horse fittings and gold leaves. As well as, he had considered this tomb belong Khünnü (Xiongnu) period and symbols on gold leaf are Khünnü's (Xiongnu's) inscription.

In 1984, Mongolian and Soviet joint historical and cultural expedition has excavated 5 tombs at place called Teel in Khutag-Öndör soum and discovered interesting features in funeral practices involve placing the dead human head to the north, face to the west, legs were folded and bones from sheep and goat.

In 1987, the research team of Mongolian and Soviet historical and cultural joint expedition including researcher, archeologist D.Navaan, T.Sanjmyatav, V.V.Volkov Institute of History, Mongolian Academy of Sciences, have examined and excavated tombs at Khovd, Bulgan and Arkhangai province, which belong to periods of history. Besides with this, they have examined deer stones, petroglyphs and wrote definitions of them. As well as, they have excavated 2 Khünnü tombs (Xiongnu) at basin of river Eg in Khantai bagh of Khutag-Öndör soum and discovered interesting findings, such as deer horn and vase fragments etc.

